

## Ашиг сонирхол гэж юу вэ?

Хувийн ашиг  
сонирхол  
гэдэг нь :



Эцэг эх, төрсөн ах, эгч дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхрийн/-ийн эцэг эх, төрсөн ах, эгч дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдтэй холбоотой хүмүүсийн сонирхлыг багтаан ойлгодог. Нийтийн албан тушаалтан албаны үүргээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг хэлнэ.

Нийтийн ашиг  
сонирхол  
гэдэг нь :



Нийтийн албан тушаалтан монгол улсын нэгдсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш шударгаар хэрэгжүүлнэ гэсэн олон нийтийн итгэлийг хэлнэ. Хувь хүн бүрийн сонирхлын нийлбэр, эсхүл тухайн нэгэн бүлгийн ашиг сонирхол биш ,харин нийт иргэдийн нийтлэг сонирхол юм.

## Ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?

Трансперенси интернейшнл байгууллагын тодорхойлолт:

“Ашиг сонирхлын зөрчил гэдэг нь төрийн албан хаагч төрийн ашиг сонирхолд болон улсын ашиг сонирхолд үйлчлэхээсээ илүү төрийн нэрийн өмнөөс өөрт олгогдсон эрх мэдлээ ашиглаж өөрийн үзэмжээр хувийн ашиг сонирхолдоо үйлчлэх нөхцөл байдлыг ойлгоно.”

